

**“ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА УСАЛГААТАЙ ХӨДӨӨ  
АЖ АХУЙ” ТӨСӨЛ**

**“БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН**

**БАТЛАВ. БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-Н ДАРГА**

**Б.БУЯННЭМЭХ**

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

**АГРО-АЛФА ХХК-ИЙН ЗАХИРАЛ**

**О.ГАНБААТАР**

**ХОВДАЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**РЕГИСТРИЙН ДУГААР: 5106621**

**ХЯНАСАН:**

**БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-Н МЭРГЭЖИЛТЭН**

**П.ШИНЭЦЭЦЭГ**

**БОЛОВСРУУЛСАН :**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, ЗӨВӨЛГӨӨНИЙ  
“ХАС ЦАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:**

**Н.ОЮУНТУУЛ**

**УЛААНБААТАР ХОТ  
2023ОН**

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Агуулга

<b>ОРШИЛ</b> .....	<b>2</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>4</b>
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2 Төслийн байршил: .....	4
1.3 Услалтын системийн өнөөгийн байдал.....	5
1.4 Төслийн ерөнхий төлөвлөлт, хүчин чадал.....	8
1.5. <i>Услалтын системийн ерөнхий төлөвлөгөө</i> .....	8
1.6 Услалтын системийн хүчин чадал.....	14
1.7 Ажиллах горим .....	15
Төслийн технологи, техник тоног төхөөрөмж .....	<b>ERROR! BOOKMARK NOT DEFINED.</b>
<b>1.8 Усалгаатай тариалангийн технологи</b> .....	<b>20</b>
<b>1.9. Техник, тоног төхөөрөмж</b> .....	<b>21</b>
1.10 Түүхий эд, туслах материал.....	22
<b>1.10.1. Ус хангамж, хэрэглээ</b> .....	<b>22</b>
<i>“Боомын ам” услалтын системийн усны эх үүсвэрийг төслийн талбайгаас 3-4 км-ийн зайд урсан өнгөрөх Бодонч голоос хангахаар төлөвлөсөн. Ингэхдээ ус татах толгойн барилга болон гол сувгаар дамжуулан усыг 18000 м<sup>3</sup> (Цэврээр) эзлэхүүнтэй усан санд хүргэж, усан сангаас насос станцын тусламжтайгаар усыг далд сүлжээгээр дамжуулан 5 бороожуулах төхөөрөмжинд шахаж тариалангийн талбайг услана.</i> .....	22
<b>Үрийн хэрэглээ</b> .....	25
<b>1.10.2 Эрдэс бордоо, пестицидийн хэрэглээ</b> .....	<b>25</b>
Эцсийн бүтээгдэхүүн .....	28
Хог хаягдал .....	28
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>29</b>
2.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ .....	29
<b>2.3. Нөхөн сэргээлийн төлөвлөгөө</b> .....	<b>40</b>
<b>2.4. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө</b> .....	<b>41</b>
<b>2.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө</b> .....	<b>41</b>
<b>2.6. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө</b> .....	<b>41</b>
<b>2.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</b> .....	<b>43</b>
<b>2.10. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)</b> .....	<b>50</b>
<b>2.11. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь</b> .....	<b>54</b>

# ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## ОРШИЛ

Ховд аймгийн Алтай сумын нутаг дэвсгэрт орших “Боомын ам” услалтын системийн анхны зураг төслийг 237 га талбайг услахад зориулж 1976 онд боловсруулж, барилгын ажлыг 1978 онд эхлүүлсэн боловч төрөөс 1000 га талбайд усалгаатай тариалан эрхлэх үүрэг өгсний дагуу талбайн хэмжээг нэмэгдүүлж, нийт 757 га талбайтай услалтын системийг 1979 онд ашиглалтанд оруулан үр тариа (арвай), олон наст, нэг наст ургамал тариалж эхэлсэн байна.

Ашиглалтын эхний 10 жилд усалгаатай тариалангийн технологийг нарийн чанд мөрдөөгүйгээс талбайн 50-70 хувийг нь ашиглаж, га-ийн ургац харьцангуй бага авч байсан байна. 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжих явцад услалтын системийн тоног төхөөрөмж эвдэрч, тоногдсоноор, зөвхөн толгойн барилга, гол суваг, усан сан л үлдэж, услалтын системийн ашиглалт зогссон байна. Иймд АХБ-ны санхүүжилтээр ХХААХҮЯ-аас хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд уг услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээ болон БОАЖЯ-ны 2022 оны 02 сарын 23-ны өдрийн 13/760 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн “Грийн Натур Ланд” ХХК, “Нью Грийн Ворлд” ХХК, “Экос” ХХК хамтран боловсруулсан байна.

### **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго**

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад зорилго оршино.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан төлөвлөгөөг ойлгоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газар, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн бол сумын Засаг даргад хүргүүлэн хянуулж батлуулна.

Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага болон сумын Засаг дарга хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн бичиг баримт болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОННУ-ний тайланг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга хэсгүүд баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана.

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа нь зах зээл, эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт үзэгдэл, тухайн бүс нутаг, хүн амыг хамарсан халдварт өвчин, тахал зэрэг давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас зогсонги байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 1 сарын дотор хандан, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулах хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй талаарх тодорхойлолтыг төсөл хэрэгжиж буй сум, дүүргийн Засаг дарга хэд хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн хувьд аймаг, нийслэлийн байгаль орчны газар тодорхойлсон байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү журамд заасан шаардлагыг хангаж боловсруулаагүй бол түүнийг хүлээн авч хянах, батлахаас татгалзах үндэслэл болно.

Ашигт малтмал ашиглах, хайх, дэд бүтцийн барилга байгууламж барих зэрэг улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тэдгээрийн тухайн оны төлөвлөлттэй уялдуулан эхний улиралд багтаан хянаж, эцэслэн батална.

Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1.1 Төслийн ерөнхий мэдээлэл**

**Төслийн нэр:** “Боомын ам” услалтын систем

**Төслийн зорилго:**

Энэхүү төслийн үндсэн зорилго нь услалтын системийг сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, ногоочид, тариаланчдын чадавхи, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, шинээр ажлын байр бий болгоход оршино.

**Төслийн захиалагч:** Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)

**Улсын бүртгэлийн дугаар:** 9070003115

**Регистрийн дугаар:** 9132287

**Хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, ЗГ-ын 9-р байр

**Утас:** 452554, 456955

**Төсөл хэрэгжүүлэгч:** Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл

**Улсын бүртгэлийн дугаар:** 9069001088

**Регистрийн дугаар:** 6610935

**Хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Хоршоологчдын холбооны байр, 511 тоот


**Утас:** 99117994

**Төслийн санхүүжүүлэгч:** Азийн Хөгжлийн банк (АХБ)

**1.2 Төслийн байршил:**

“Боомын ам” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь Ховд аймгийн Алтай сумын нутаг дэвсгэрт байрлана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун урд зүгт 1450 км зайд, аймгийн төвөөс урд зүгт 300 км зайд, Алтай сумын төвөөс баруун урд 2-3 км зайд оршино. Алтай сум нь өмнө талаараа БНХАУ, баруун талаараа Ховд аймгийн Үенч, хойт талаараа Мөст, зүүн хойд талаараа Цэцэг, зүүн урд талаараа Говь-Алтай аймгийн Тонхил сумтай тус тус хиллэдэг.

# ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1. “Боомын ам” усалтын системийн төсөл хэрэгжих талбайн байршил

Төсөл хэрэгжих хугацаа:

АХБ-ны санхүүжилтээр ХХААХҮЯ-аас хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд “Боомын ам” усалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг 2022 оны 3-р улиралд эхлүүлж, 2023 оны 2-р улиралд дуусгах бол тоног төхөөрөмжийг худалдан авах, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах ажлыг 2022 оны 3-р улиралд эхлүүлж, 2023 оны 1-р улиралд дуусгахаар төлөвлөсөн байна. Ингэснээр усалтын системийг 2023 оны 2-р улирлаас бүрэн ашиглалтанд оруулах боломжтой болно.

### 1.3 Усалтын системийн өнөөгийн байдал

“Боомын ам” усалтын системийн анхны зураг төслийг 237 га талбайг услахад зориулж 1976 онд боловсруулсан ба 6.5 км урт бетон доторлогоотой суваг, 3 ш зөөврийн шахуурга станц (СНП 50/80), 1 ширхэг бороожуулах төхөөрөмж (МА-200), тус бүр 72 га талбайг услах 3 комплекс усалгааны төхөөрөмж (ДКШ 64/800 Волжанка)–тэй байхаар төлөвлөсөн байна.

Зураг төслийн дагуу усалтын системийн барилгын ажлыг 1978 онд эхлүүлсэн боловч төрөөс 1000 га талбайд усалгаатай тариалан эрхлэх үүрэг өгсний дагуу талбайн хэмжээг нэмэгдүүлж, нийт 757 га талбайтай усалтын системийг 1979 онд ашиглалтанд оруулан үр тариа (арвай), олон наст, нэг наст ургамал тариалж эхэлсэн байна.

Ашиглалтын эхний 10 жилд усалгаатай тариалангийн технологийг нарийн чанд мөрдөөгүйгээс талбайн 50-70 хувийг нь ашиглаж, га-ийн ургац харьцангуй бага авч байсан байна. 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжих явцад усалтын системийн тоног төхөөрөмж эвдэрч, тоногдсоноор, зөвхөн толгойн барилга, гол суваг, усан сан л үлдэж,

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

услалтын системийн ашиглалт үндсэндээ зогссон байна. Үүнээс хойш услалтын системийн толгойн барилгын засварыг 2006 онд, толгойн барилга болон гол сувгийн хэсгийн засвар шинэчлэлтийн ажлыг 2019 онд тус тус хийсэн байна. Мөн толгойн барилгын дээд талд толгойн барилга руу орох усыг нэмэгдүүлэх зорилгоор голын зүүн салааг хаан урсгал чиглүүлэх далан барьсан байна.



**Зураг 2.2019 онд Толгойн барилгын хаалтны засвар хийгдэхээс өмнөх үе**



**Зураг 3.Толгойн барилгын хаалтуудыг 2019.06.22-нд засварлаж дууссан байдал**



**Зураг 4. Засварласан хаалтууд**



**Зураг 5. Услалтын системийн толгойн барилга**



**Зураг 6.Толгойн барилгын хаях суваг /илүүдэл ус/**





**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**



**Зураг 7. Гол суваг, толгойн барилгын гол сувагтай холбогдсон хэсэг**

Түүнчлэн Баруун бүсийн босоо тэнхлэгийн шинэ хурдны зам толгойн барилга, гол сувагт ойрхон тавигдсан /Зураг 8/.



**Зураг 8. Бодонч голын эрэг дагуух баруун бүсийн хурдны босоо зам**

Талбайн хойд талд гол сувгийн ПК48+00 цэгт хуучин усан сан (эзлэхүүн 18000 м<sup>3</sup>, ёроолын урт 95 м, өргөн 60 м, гүн 2.5 м) байрлана. Шинэчлэлт хийхээр төлөвлөсөн 300 га талбайн гадна W=8000 м<sup>3</sup> эзлэхүүнтэй (ёроолын өргөн 10 м, хажуу налуу m=3.0, гүн 2.5 м) цөөрөм байрладаг.



**Зураг 9.Ус тохируулгын /хуримтлуулах/ цөөрөм**

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хуучин усалтын системийг бүхэлд нь уулын урд энгэрийн жалга, сайраас ирэх уруйн үерээс хамгаалах 9.65 км урт уулын суваг нэлээд эвдэрч муудсан ба ялангуяа уулын жалга, сайрууд огтлолцсон хэсгүүдээр угаагдаж сэтрэн, хагшааст дарагдсан байна. Уулын суваг машин замтай огтлолцсон /зориулалтын гарамгүйгээс/ дөрвөн хэсэгт бүрэн эвдэрсэн. Сувгийн эвдрэл, хагшааст дарагдсан байдал нь үерийн эрсдэл их байгааг харуулж байна. Иймээс усалтын системийг бүхэлд нь хур борооны болон уулын уруйн үерээс хамгаалахын тулд тус сувгийг дахин засварлах шаардлагатай болсон байна.

### 1.4 Төслийн ерөнхий төлөвлөлт, хүчин чадал

Энэхүү төсөл нь үндсэндээ 2 үе шаттай хэрэгжинэ. Үүнд:

1. Усалтын системийн барилгын ажил (Усалтын системийн толгойн барилга, усан сангийн барилга байгууламжийг шинэчлэн барих, усалгааны тоног төхөөрөмжийг угсрах, ус татах, дамжуулах хоолойг суурилуулах г.м)
2. Усалтын системийг ашиглалтанд хүлээн авч 300га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоог усалгаатай тариалах

### 1.5. Усалтын системийн ерөнхий төлөвлөгөө

Төслийн зураг төслөөс үзэхэд усалтын системийг шинэчлэхээр төлөвлөсөн 300 га талбайд инженер-геодезийн хэмжилт хийснээс нийт талбай бохироор 327.7 га байгаа ба үүнээс усалгаатай цэвэр талбай 252.7 га-г ашиглахаар төлөвлөсөн байна.

Усалтын системийн ажиллах зарчим: Бодонч гол дээр баригдсан дөхүүлэх суваг, ус татмын (ГВС-2.0х2.5х1.2 нэг загварын толгойн барилга) барилга болон гол сувгаар дамжуулан усыг 20000 м<sup>3</sup> эзлэхүүнтэй усан санд хүргэнэ. Усан сангаас насос станцын тусламжтайгаар усыг далд сүлжээгээр дамжуулан 5 бороожуулах төхөөрөмжинд шахаж тариалангийн талбайг услана.

**Хүснэгт 1. “Боомын ам” усалтын системийн төлөвлөлтийн үндсэн үзүүлэлтүүд**


№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b>I. Үндсэн үзүүлэлт</b>			
1	Талбай	Бохир	га
		Цэвэр	га
2	Газар ашиглалтын коэффициент	-	0.77
3	Хангамшил	Усны эх үүсвэр-Бодонч гол, м <sup>3</sup> /сек	м <sup>3</sup> /сек
		P <sub>1%</sub>	м <sup>3</sup> /сек
		P <sub>2%</sub>	м <sup>3</sup> /сек
		P <sub>5%</sub>	м <sup>3</sup> /сек
4	Ус авах арга – ус татамжийн толгойн барилгын хүчин чадал	P <sub>10%</sub>	м <sup>3</sup> /сек
		Ус авах арга – ус татамжийн толгойн барилгын хүчин чадал	м <sup>3</sup> /сек
		Суурин насос станц	-
		Зарцуулга, м <sup>3</sup> /сек	м <sup>3</sup> /сек
5	Насосны төрөл – Үндсэн болон нөөц	Түрэлт	ш
		Хүчин чадал	м
		Цахилгаан эх үүсвэр – сум дундын цахилгаан шугам	кВт
		Цахилгаан эх үүсвэр – сум дундын цахилгаан шугам	кВт
		Усалгааны арга	кВт
6	Усалгааны арга	Бороожуулах, дуслын усалгаа	Бороожуулах, дуслын усалгаа
		Тойргоор тэнхлэгээ тойрч услах бороожуулагч	ш
		Дуслын усалгаа	Иж бүрдэл
7	Усалгааны техник	Тойргоор тэнхлэгээ тойрч услах бороожуулагч	ш
		Дуслын усалгаа	Иж бүрдэл

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

		Дуслын усалгааны төхөөрөмж	Нарны үүсгүүрээр ажиллах насос (CRPlex 3-11/CRPlex 1-17)	ш	24/3
			Нарны хавтан	ш	27
8	Бороожуулагч машины тоо	DYP-7		ш	2
		DYP-8		ш	3
<b>II. Усны барилга байгууламжийн үзүүлэлт</b>					
9	Усалгааны ил сүлжээ	Гол суваг		м	4870
		Хаях суваг		м	910
10	Усалгааны далд сүлжээ	Гол хоолой, ГХ, Ø 450 мм Ø 355 мм		м	1277/820
		Хувиарлах хоолой, ХХ, Ø 280 мм		м	1644
		Юүлэх хоолой (суллах), ЮХ, Ø 100 мм		м	889
11	Бусад сүлжээ	Ашиглалтын зам		м	13140
		Ойн зурвас		м	12430
		Хашаа		м	12800
		Цахилгааны шугам шинээр тавих		км	2.32
		Цахилгааны шугам талбайгаас гаргаж шилжүүлэх		км	2.1
12	Трансформаторын дэд бүтэц			ш	1
13	Барилга байгууламжууд болон бусад тоноглолууд	Хуваарилах худгууд		ш	5
		Юүлэх худаг (Хаалттай)		ш	3
		Юүлэх худаг		ш	3
		Бороожуулагчтай холбох холболт		ш	5
14	Хөдөө аж ахуйн техник	Экскаватор		ш	1


Төслийн үндсэн барилга байгууламжуудын ерөнхий төлөвлөлтийн план зургуудыг Зураг 10 ~ 13-т тус тус харуулав.

ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 10. Услалтын системийн ерөнхий төлөвлөгөө (М1:20000)

# ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 11. Услалтын системийн ерөнхий төлөвлөгөө (Тариалангийн талбайн орчим)

ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



12.Услалтын системийн ерөнхий төлөвлөгөө (Толгойн барилга, гол сувгийн дагуух хэсэг)

ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 13. Усан сангийн төлөвлөлт

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**1.6 Усалалтын системийн хүчин чадал**

“Боомын ам” усалалтын системийн төсөл хэрэгжсэнээр DYP - 7 болон DYP - 8 марк бүхий хоёр төрлийн тойргоор услах 5 ш бороожуулагч машинаар 252.7 га талбайг услахаар төлөвлөсөн. Эдгээр 5 бороожуулагч нь хоногт бүрэн хүчин чадлаараа 2 ээлжээр буюу 16 цаг ажиллана. Гэхдээ 5 бороожуулагч зэрэг ажиллахгүй бөгөөд нэгэн зэрэг 3 бороожуулагч ажиллахаар төлөвлөн насосны хүчин чадлыг сонгосон.

Усалгаатай тариалангийн талбайн 111.8 га-д үр тариа, 55.9 га-д эрдэнэшиш /тэжээл/, 74.4 га-д төмс, 10.6 га-д хүнсний ногоо тариалахаар зураг төсөлд тусгажээ (Зураг 2-14, Хүснэгт 2-2). Үүнээс гадна дуслын усалгааны системээр услах гол суваг болон талбайн ойн зурвасын талбай 10.24 га байна.



**Зураг 14. Таримлын усалгаатай талбайн хуваарилалт**

**Хүснэгт 2. Усалгаатай талбайд тариалах таримлын төрөл, талбайн хэмжээ, ургац**

Таримлын төрөл	Талбайн усалгааны арга	Усалгаатай тариалах талбайн хэмжээ, га	Нийт талбайд эзлэх хувь, %	Га-ийн ургац цн	Нийт ургац, тн (бохироор)	Хорогдол		Цэвэр ургац тн
						%	тн	
Төмс, га	Бороожуулагч (Төвөө тойрон эргэх усалгаа)	74.4	28.3	100	781.2	8.0	62.5	718.7
Хүнсний ногоо, га		10.6	4.0	80	90.1	8.0	7.2	82.9
Хөх тариа, га		111.8	42.5	20	223.6	5.0	11.2	212.4
Эрдэнэшиш /Овьёос, га		55.9	21.3	30	195.7	5.0	9.8	185.9
Жимсний мод, салхинаас	Дуслын усалгаа	10.24	3.9	-	-	-	-	-



**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

хамгаалах ойн зурвас, га								
<b>Нийт талбай</b>		<b>262.94</b>	<b>100</b>	<b>-</b>	<b>1290.6</b>	<b>-</b>	<b>90.7</b>	<b>1199.9</b>

*\*Тайлбар: 1 цн=0.1 тн*

“Боомын ам” усалтын системийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах үед үр тариа (Хөх тариа) 212.4 тн, эрдэнэшиш 185.9 тн, хүнсний ногоо 82.9 тн, төмс 718.7 тн-ыг хураан авна. Тус талбайд хамгийн сүүлд 2016 онд тариалалт хийж, түүнээс хойш өнөөг хүртэл тариалалт хийгээгүй байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр га-аас авах ургацын хэмжээ 2016 оноос 1.3-1.7 дахин нэмэгдэж, усалгаатай тариалан үйлдвэрлэлийн голлох үзүүлэлт болох нэгж талбайгаас авах ургац болон хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ өснө /Хүснэгт 3/.

**Хүснэгт 3. Усалгаатай тариалангийн бүтээгдэхүүний өсөлт**

Таримлын нэр	2016 онд			Усалтын систем ашиглалтанд орсноор		
	Тариалсан талбай	Ургац, тн	га-ийн ургац, цн	Тариалах талбай	ургац, тн	га-ийн ургац, цн
Үр тариа	3.0	4.0	13.33	111.8	212.4	20
Төмс	8.6	51.6	60.0	74.4	718.7	105
Хүнсний ногоо	9.3	56.8	61.08	10.6	82.9	85
Эрдэнэшиш	-	-	-	55.9	185.9	35
Бүгд	20.9			252.7		

*\*Тайлбар: 1 цн=0.1 тн*

### **1.7 Ажиллах горим**

Усалгаатай тариалангийн тариалалтын ажлыг жил бүрийн 3-р сарын 15-аас эхлүүлж 10-р сарын 20-ны үед ургац хураалтын ажлыг дуусгах ба жилд дунджаар 220 хоног тариалангийн үйл ажиллагаа эрхэлнэ. Төслийн зураг төсөлд тусгаснаар нийт 44 хүн ажиллах ба үүнээс 11 нь бүтэн цагаар жилд 12 сарын турш, 33 нь жилд 6 сар ажиллахаар тооцсон байна.

“Боомын ам” усалтын системийн төсөл хэрэгжсэнээр:

- Ус татах толгойн байгууламж
- Гол суваг
- Усан сан
- Насос станц
- Ус дамжуулах далд сүлжээ
- Бороожуулах машин
- Ойн зурвас
- Дуслын усалгааны систем зэрэг үндсэн болон туслах барилга байгууламж,

тоног төхөөрөмжийг суурилуулахаар ажлын зурагт тусгасан байна.

**Ус татах байгууламж:** Дөхүүлэх ба хаях сувгийн ёроолын өргөн  $b=2.0$  м; налуу  $m=1.5$  м; тооцоот ус өнгөрөх үеийн усны гүн  $h=0.7$  м байна.

**Толгойн барилга:** Бодончийн гол дээр 1978 онд /2006 онд засварласан/ баригдсан хуучин толгойн барилга (ус татах барилга ГВС-2.0 х 2.5 х 1.2) болон гол сувгийг (ГС) дахин ашиглахаар төлөвлөсөн байна. 2019 оны 6-р сард орон нутгийн санхүүжилтээр толгойн барилгын хавтгай хаалтуудыг шинэчлэн сольж, гол сувгийн лайг цэвэрлэн, эвдрэл, гэмтлийг засварласан байна.

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


Толгойн барилгын ус авах хүчин чадал  $Q=1.2 \text{ м}^3/\text{сек}$ , хаях барилгын хүчин чадал нь  $Q=5.4 \text{ м}^3/\text{сек}$  болно.

**Гол суваг:** Одоо байгаа бетон доторлогоотой гол сувгийн эхний 4.8 км сувгийг засварлаж ашиглана. Сувгаар өнгөрөх тооцоот зарцуулга нь  $Q=0.555 \text{ м}^3/\text{сек}$ , налуу  $m=1.5$ , ёроолын өргөн  $b=1.0 \text{ м}$ , усны гүн  $h=0.7 \text{ м}$ .

**Усан сан:** Гол сувгийг өмнө байгуулсан усан сантай холбоно. Одоо байгаа  $18000 \text{ м}^3$  эзлэхүүнтэй хуучин усан сангийн лайг цэвэрлэж томсгон, сэргээн засварлаж, шүүрлээс хамгаалсан доторлогоо хийхээр төлөвлөсөн байна. Усан сан болон гол сувгийг холбосон сувагт засвар хийж, усан сангийн оролтын хэсэг болон илүүдэл ус зайлуулах хэсгийг засварлан, хаях сувагтай /ослын/ холбоно. Усан сангийн нийт эзлэхүүн  $23851 \text{ м}^3$ , ёроолын урт 98 м, өргөн 62 м, гүн 2.5 м, ашигтай эзлэхүүн  $18000 \text{ м}^3$ , ууршилтанд алдах алдагдал  $2502 \text{ м}^3$ , үхмэл эзлэхүүн  $3420 \text{ м}^3$  болно.

Усан сангийн усны түвшинг гол сувгийн болон усан сан дахь халиагчаар тохируулна. Ус хаях сувгаар илүүдэл ус зайлуулах ба шавхах тохиолдолд ёроолын ус гаргуураар гаргана. Усалгаа дууссаны дараа усан сангийн усыг хоослоно.

**Насос станц:** Усан сангаас усыг насосаар далд сүлжээ рүү шахаж, далд сүлжээгээр /хоолойгоор/ дамжуулан тойргоор усалдаг бороожуулагчдыг усаар хангана. Насос станцад 2 ширхэг NB 250-450/365 AF1ABAQE маркийн насос суурилагдана.



Зураг 15. NB 250-450/365 AF1ABAQE

Насосны техникийн үзүүлэлт маркийн насос

**Ус дамжуулах далд сүлжээ:** Усан сангаас усыг насосаар далд сүлжээ рүү шахаж, далд сүлжээгээр /хоолойгоор/ дамжуулан бороожуулагчдыг усаар хангах болон далд сүлжээг өвлийн хадгалалтанд тавихын тулд сүлжээг суллах /хоослох/ далд юүлэх хоолой, төгсгөлд нь юүлэх худгууд тавигдана. Далд сүлжээ нь өндөр даралтын хуванцар хоолойнууд байна. Гол хоолойн нийт урт 1453 м, голч 450 мм. Хуваарилах хоолойн урт 824 м, голч 360 мм, хэсгийн буюу усалгааны хоолойн голч 280 мм, нийт урт 1640 м. Шугамын усыг юүлэх хоолойн голч 100 мм, нийт 889 м.

Далд шугам хоолойнуудад засвар үйлчилгээ, үзлэг хийх болон усыг хуваарилах зориулалт бүхий 5 худаг төлөвлөв. Услалтын системийн далд сүлжээг өвлийн улиралд аюулгүй хадгалахын тулд усыг өөрийнх нь урсгалаар далд хоолой, болон юүлэх худгаар тус тус зайлуулна.

**Усалгааны бороожуулагч машин:** Услалтын системийн талбай 5 хэсгээс бүрдэх ба I, II талбайд DYP-7 бороожуулагч, III IV, V хэсгүүдэд DYP-8 бороожуулагчийг байрлуулна. DYP-7 маркийн 2 ширхэг бороожуулагч машинууд нь 369 м урттай бөгөөд 42.5 га талбайг

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

услах хүчин чадалтай. Бүрэн механик ажиллагаатай DYP-8 бороожуулагч машин нь 424 м урттай бөгөөд 55.9 га талбайг тойргоор услана. Эдгээр бороожуулагч машинуудын ус ашиглалт нь 0.85 %, бороожуулагчийн эрчимшил 0-55 мм, явах хамгийн их хурд 156 м/ц болно.


**Хаях суваг:** Гол сувгийн төгсгөлд байрлах 910 м урттай хаях сувгаар илүүдэл усыг зайлуулна. Сувгийн эхлэл, төгсгөлд урсгал зохицуулах хаалтууд байрлана.

**Ус гаргуур:** Гол сувгийн дагууд гол сувгийг гатлах яндант ус гаргуур нийт 5 ширхэг төлөвлөсөн.

**Ойн зурвас, усалгааны арга:** Гол сувгийн дагууд болон усалалтын системийн талбайг тойруулан салхины хүч, ууршилтаас хамгаалсан ойн зурвас байгуулна.


Усалалтын системийн талбайг тойруулан шинээр байгуулах ойн зурвас нь 3 эгнээ, 8 м-ийн өргөнтэй 7.4 км урт байна. Ойн зурвасын мод хоорондын зай нь 3.0 м, эгнээ хоорондын зай нь 3.0 м, бут /сөөг/ хоорондын зай 1.5 м, том мод хүртэл 2 м, хашаа болон талбайн зах хүртэл 2 м байна.

Гол суваг дагуух ойн зурвас 2 эгнээ 6.0 м өргөнтэй, нийт урт 7.32 км болно. Мод хоорондын 3.0 м, эгнээ хоорондын зай нь 3.0 м байна /Зураг 2-17/.



**Зураг 16 . Ойн зурвасын дуслын системийн ажиллах зарчим**


Ойн зурвасыг услах усны эх үүсвэр нь гол суваг, усан сан, хаях сувгийн ус байх ба нарны энергээр ажиллах насос (CRPlex 3-11)-оор усыг шагаж, дуслын усалгааны иж бүрдэл системээр усалгаа хийнэ. Дуслын усалгаагаар ойн зурвас, ногоон байгууламжийг услах нь шуудуу татан ил аргаар услахаас усны алдагдлыг 70-80% хүртэл бууруулна.




**Зураг 17. Ойн зурвасын усны эх үүсвэрийн схем**

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


Гол сувгийн дагуух 2 эгнээ ойн зурвасыг услах дуслын усалгааны нэг иж бүрдэл нь 100 ш модыг зэрэг услана. Харин усалалтын талбайн 3 эгнээ ойн зурвасыг услах дуслын усалгааны нэг иж бүрдэл нь 100 ш мод, мөн 100 ш бутыг услах боломжтой. Ойн зурвасын усалгааг 16 цагаар хийхэд нийт 6 хоногт бүх модыг усалж дуусна.




**Зураг 18. Дуслын усалгааны системийн бүдүүвч**



**Зураг 19. Дуслын усалгааны системийн бүдүүвч-Усан сангаар дамжуулан усаар хангах**



**Зураг 20. Голын сувгийн дагууд тарих 2 эгнээ ойн зурвасыг услах дуслын усалгааны нэг иж бүрдлийн схем**



**Зураг 21. Тариалангийн талбайн захаар тарих 3 эгнээ ойн зурвасыг услах дуслын усалгааны нэг иж бүрдлийн схем**

## ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Цахилгаан хангамж:** Сумын төв нь 2010 оны 12 дугаар сараас БНХАУ-ын Шинжан Уйгараас татсан цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Талбайн дундуур суурилагдсан цахилгаан дамжуулах агаарын шугамыг талбайд хойд талаар шилжүүлэн тавина.

**Үерийн хамгаалалтын уулын суваг:** Үерийн хамгаалалтын 9.65 км урт уулын сувгийн араар хатуу хучилттай автозам тавигдсан бөгөөд үерийн сувгийн эхний хэсгийн 1.5 км хэсэг авто замын цаад талд орсон байна. Түүнчлэн толгойн барилгын дээд талаас 2.43 км урт үерийн хамгаалалтын уулын сувгийн эхлэлийн хэсгийг дахин шинээр байгуулна. Энэ нь одоо байгаа сувгийн ПК2+61 цэгтэй холбогдоно. Учир нь тус пикет хүртлэх сувгийн эхний хэсэг үндсэндээ бүрэн эвдэрч, хагшаасанд дарагдан ашиглах боломжгүй болсон байна. ПК2+61 хэсгээс доош уулын сувгийн төгсгөл хүртэл хөндлөн огтолсон бүх л жалга, сайраар урсах усны нөлөөгөөр хэсэгчилэн сэтэрч, эвдрэн хагшаасанд дарагдсан байх ба эвдэрсэн хэсгүүдийг дахин засварлаж, хагшаасыг цэвэрлэн ашигласнаар услалтын системийг бүхэлд нь шар ус, хур борооны үерээс хамгаалах боломж бүрдэнэ.

**Ашиглалтын зам, торон хашаа:** Ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах зорилгоор талбайн шороон замыг хувиарлах ба усалгааны далд хоолойн дагууд байхаар төлөвлөсөн байна. Замын өргөн  $b=6.5$  м, нийт урт нь 13.14 км.

Шинээр татах хашаа нь 5.0 м-ийн алгаслалтай төмөр бетон шонтой 12.5 км урт төмөр утсан торон хашааг талбайн эргэн тойронд татах ба 2 хаалгатай байна.

**Газар шорооны ажил:** Хуванцар хоолой байрлах шуудууг өнгөн хөрсийг хуулсны дараа экскаватороор ухаж шуудууны ёроолыг нивелирдэн 20 м тутамд төслийн тэмдэгтэд модон гадас зоож түүнтэйгээ уялдуулан гараар тэгшилгээ хийж янданг оруулж тавихад бэлтгэнэ.

Газар шорооны ажлыг механизмаар гүйцэтгэхэд хэтэрхий гүнзгий ухаж болзошгүй бөгөөд тэр нь дахин шороо хийж дээр нь барилга байгууламж, хуванцар хоолой зэргийг байрлуулахад сул шороо суудаг муу нөлөөтэй учраас хэт ухуулахгүйн тулд төслийн тэмдэгтийн зохих түвшнээс 10 см орчим үе орхин дутуу ухуулж дараа нь гараар гүйцээж ухуулж байх хэрэгтэй.

Хуванцар хоолой болон бусад арматуруудыг шуудуунд төслийн тэмдэгтэд байрлуулсны дараа гараар булж, 2 талаар нь хөдөлгөөнгүй болгож хоолойн залгаасын бат бэхийг усаар буюу хийгээр шахаж шалгана. Хоолойн холболтыг бүрэн шалгасны дараа яндангийн нуруун дээр 20 см хүртэл зузаан шороог шуудууны налууг дагуулж бульдозерээр түрж гараар тарааж овоолно. Үүнээс дээших хэсгийг бульдозерээр түрж тэгшилнэ. Бульдозерээр үндсэн шороог тэгшилсний дараа ургамлын өнгөн хөрсийг тарааж өгнө. Түрж тэгшилсэн шороо нь нягтруулга муутай тул суун хотойдог учир шуудууны дээр гөвгөр болгон үлдээх хэрэгтэй.

**Бетоны ажил:** Уг системд бетоны ажил нилээд хэмжээгээр хийгдэнэ. Усан сангийн ус авах хэсэг, тохируулах худгууд, гарц зэрэг барилгуудад цул ба цул төмөр бетоны ажлууд хийгдэнэ. Зохих марканд тохируулсан нормын дагуу зуурсан зуурмагийг хамгийн явцуу өнцөг булангаас эхлэн үелүүлэн хийж цутгаж нягтруулна. Барилгын бетон хана цутгасанаас хойш 3-аас доошгүй хоногийн дараа цутгасан эдлэлээ доргиож эвдэхгүй салгаж авах хэрэгтэй. Бетон эдлэлийг бэхжиж хатсаны дараа булагдах хэсгийг битумээр будаж шороогоор буцааж булаах ажил хийнэ.

**Хуванцар хоолой хоолойг угсрах ажил:** Услах системийн гол, хувиарлах, усалгааны хоолойнуудад  $D_u=450, 300, 250$  мм – ийн голчтой 11.99 км урт хуванцар хоолой угсрана.

# ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 1.8 Усалгаатай тариалангийн технологи

Услалтын системийн буюу усалгаатай тариалангийн технологи нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Бэлтгэл ажил
- Тариалалтын ажил
- Таримлын ургалтын үеийн ажиллагаа
- Ургац хураалт
- Төгсгөлийн ажил

Бэлтгэл ажил: Бэлтгэл ажлаар тариалалтын болон усалгааны машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, тариалах талбайг боловсруулах, бэлтгэх, тариалах үр, үрсэлгээгээ бэлтгэх зэрэг ажлуудыг графикайн дагуу гүйцэтгэнэ.

Тариалалт: Усалгаатай тариалахаар төлөвлөсөн талбайд тарималуудын үр, суулгацыг тухайн үеийн цаг уурын нөхцөл байдал, тарилтын төлөвлөсөн хугацаа зэргийг харгалзан тариална. Тариалалтыг зориулалтын техник хэрэгслээр гүйцэтгэнэ.

Таримлын ургалтын үе: Энэ үе шатанд цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан усалгаа хийх, хор бордоо цацах, зэрлэг ургамалтай тэмцэх, таримал тус бүрийн онцлогт тохирсон арчилгаа зэргийг гүйцэтгэнэ.

Ургац хураалт: Тарималуудын болцын байдал, тухайн үеийн цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан ургац хураалтыг тусгай зориулалтын техник болон гараар хураана. Хураасан ургацаа хадгалах болон борлуулахаар нь ангилан ялгаж тээвэрлэлтэнд бэлтгэнэ.

Төгсгөлийн ажил: Ургац хурааж дууссаны дараа ургац хураалтанд ашигласан машин, техник, тоног төхөөрөмжөө тусгай талбайд байрлуулан хадгалалтанд бэлтгэх, ирэх жил тариалах талбайдаа цэнэг усалгаа хийж, услалтын системийн шугам хоолой, юүлэх тоног төхөөрөмжийг хадгалалтанд бэлтгэх, хураан авсан ургацаа хадгалах, борлуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Усалгааны горим: Төсөл хэрэгжүүлэгч нь төмс, хүнсний ногооны тариалалтын ажлыг жил бүрийн 3-р сарын 15-аас эхлүүлж 10-р сарын 20-ны үед ургац хураалтын ажлыг дуусгах бөгөөд жилд дунджаар 220 хоног тариалангийн үйл ажиллагаа эрхэлнэ.

Услалтын системийн нэг удаагийн усалгааг бороожуулах машинаар 5-6 хоног хийх бөгөөд усалгаанд шаардагдах нийт машины тоо 5, нэгэн зэрэг ажиллах машины тоо 3 ширхэг байхаар төлөвлөжээ.

Таримлын ургалтын хугацаанд услах давтамж нь тухайн жилийн хур тунадас, агаарын температураас хамаарах боловч усалгааны горимын тооцоогоор таримлын ургалтын хугацаанд нийт 6-7 удаагийн давтамжтай услахаар байна.

### Хүснэгт 4. Усалгааны горим

Таримлын нэр	Услах тоо	Усалгаа эхлэх дуусах хугацаа
Үр тариа	6	V/5-VIII/14
Төмс	7	V/20-VIII/29
Хүнсний ногоо /байцаа/	6	V/20-IX/1
Эрдэнэшиш	6	V/5-VIII/14

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**1.9. Техник, тоног төхөөрөмж**

Услалтын системийн үндсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжүүд болон төмс, хүнсний ногоог усалгаатай тариалах, хураан авах үед шаардагдах тоног төхөөрөмжүүдийг хүснэгт 5-д үзүүлэв.

**Хүснэгт 5. Услалтын системийн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк, төрөл	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Хүчин чадал
<b>Услалтын системийн тоног төхөөрөмж, барилга байгууламж</b>					
1	Бороожуулагч машин	DYP-7	2	Ширхэг	Зарцуулга: 55.56 л/с Урт : 369 м Услах талбай: 42.5 га
		DYP-8	3	Ширхэг	Зарцуулга: 63.06 л/с Урт : 424 м Услах талбай: 55.9 га
2	Дуслын усалгааны төхөөрөмж	-	84	Иж бүрдэл	-
3	Нарны үүсгүүрээр ажиллах насос	CRPlex 3-11	24	Ширхэг	-
		CRPlex 1-17	3	Ширхэг	-
4	Нарны хавтан	-	27	Ширхэг	-
5	Насос станц	-	1		-
6	Насос	NB 250-450/365 AF1ABAQE	2		Q= 188.9 л/с
7	Гол хоолой, ГХ, Ø 450 мм Ø 355 мм	-	1277/820	м	-
8	Хувиарлах хоолой, ХХ, Ø 280 мм	-	1644	м	-
9	Юүлэх хоолой (суллах), ЮХ, Ø 100 мм	-	889	м	-
10	Трансформаторын дэд бүтэц	-	1	Ширхэг	-
11	Хуваарилах худгууд	-	5	Ширхэг	-
12	Юүлэх худаг (Хаалттай)	-	3	Ширхэг	-
13	Юүлэх худаг	-	3	Ширхэг	-
14	Бороожуулагчтай холбох холболт	-	5	Ширхэг	-
15	Экскаватор		1	Ширхэг	-
<b>Тариалалтын үеийн тоног төхөөрөмж</b>					
16	Гүн хавагч	КПШ-5	1	Ширхэг	-
17	Хавагч сийрүүлэгч	КП-3.8	1	Ширхэг	-
18	Үр тарианы үрлэгч	СЗП-3.6	1	Ширхэг	-
19	Борной Зиг-Заг	-	1	Ширхэг	--
20	Төмсний комбайн	КВУ-2	1	Ширхэг	-
21	Төмс үрлэгч	КСК-4	1	Ширхэг	--
22	Төмс сортлогч	КПС-15	1	Ширхэг	-
23	Тэжээл хураах машин	-	1	Ширхэг	-
<b>Ургалтын үед ашиглах техник тоног төхөөрөмж</b>					
24	Бордоо цацагч	BREDAL F2	1	Ширхэг	2500кг
25	Хор цацагч	HARDI SPRAYER	1	Ширхэг	12м/800л
26	Хор цацагч	Lemken Primus 25	1	Ширхэг	1тн
27	Хор цацагч	Булгар ОП-3000	1	Ширхэг	24м
<b>Ургац хураалтын үед ашиглах техник тоног төхөөрөмж</b>					

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

28	Төмс ухах машин	Гримме GVR-1700	1	Ширхэг	1 өдөрт*3га
29	Төмсний комбайн /төмс хураах/	Гримме DR1500	2	Ширхэг	1 өдөрт*5га
30	Төмс сортлогч		2	Ширхэг	-
31	Төмс ялган ангилах машин	Гримме Rh-12-60 Combi+WG900 tandem	1	Ширхэг	-
32	Лууван хураах комбайн	ASA-LIFT COMBI MIDI	1	Ширхэг	-
33	Лууван ачигч		1	Ширхэг	-
34	Луувангийн иш хадах машин	Гримме KP-1700	1	Ширхэг	1 өдөрт*2га
35	Сонгинийн иш хадах машин	Гримме ZKH-1500	1	Ширхэг	1 өдөрт*2га
36	Копатель	Гримме ТҮР 5170 RL 1700	1	Ширхэг	-

### 1.10 Түүхий эд, туслах материал

#### 1.10.1. Ус хангамж, хэрэглээ

“Боомын ам” усалтын системийн усны эх үүсвэрийг төслийн талбайгаас 3-4 км-ийн зайд урсан өнгөрөх Бодонч голоос хангахаар төлөвлөсөн. Ингэхдээ ус татах толгойн барилга болон гол сувгаар дамжуулан усыг 18000 м<sup>3</sup> (Цэврээр) эзлэхүүнтэй усан санд хүргэж, усан сангаас насос станцын тусламжтайгаар усыг далд сүлжээгээр дамжуулан 5 бороожуулах төхөөрөмжинд шахаж тариалангийн талбайг услана.

Харин ажилчдын унд ахуйн ус хэрэглээг төслийн талбайгаас 1.2 км зайтай байрлах гүний худгаас зөөврөөр хангахаар төлөвлөсөн.

#### Унд ахуйн ус хэрэглээ:

Усалтын системийн ашиглалтын үе буюу газар тариалан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед хэрэглэх ажилчдын унд ахуйн ус хэрэглээг БОНХАЖС-ын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12, 14-р хавсралтууд дахь ус хэрэглээний нормоор тооцоход хоногт 5.0 м<sup>3</sup> ус хэрэглэхээр байна.

$$Q_{\text{унд ахуй}} = N * q = 44 * 80 \text{ л/хон} = 3520 \text{ л/хон} = 3.52 \text{ м}^3/\text{хон}$$

Q- унд ахуйн нийт ус хэрэглээ

q\* - ус хэрэглээний норм (80 л/хон)

N- хүний тоо (44 хүн)

$$Q_{\text{ажилчдын хоол}} = N * q = 88 * 16 \text{ л/хон} = 1408 \text{ л/хон} = 1.408 \text{ м}^3/\text{хон}$$

Q- ажилчдын хоолонд хэрэглэх усны хэмжээ

q\* - ус хэрэглээний норм (16 л/таваг хоол)

N- өдөрт хийх хоолны тоо (88 ширхэг)

$$Q_{\text{унд ахуй}} + Q_{\text{ажилчдын хоол}} = 3.52 \text{ м}^3/\text{хон} + 1.408 \text{ м}^3/\text{хон} = 4.928 \approx 5.0 \text{ м}^3/\text{хоног}$$

#### Таримлын ус хэрэглээ:

Төслийн хүрээнд нийт 252.9 га талбайд төмс, хүнсний ногоо, үр тариа, эрдэнэшишийг усалгаатай тариалах ба таримлын ургалтын хугацаанд шаардагдах жилийн нийт усны хэмжээг БОНХАЖС-ын 2015 оны А/301-р тушаал, 11-р хавсралт дахь таримал ургамлын усалгааны нормын дагуу тооцож дараах Хүснэгт 6-д харуулав. Төсөл хэрэгжих Алтай сум нь мелиорацийн мужлалаар Баруун мужид, уур амьсгалын хувьд Нэн хуурай дулаан говийн



**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

мужид хамаардаг, жилийн агаарын дундаж температур 2.5 градус буюу харьцангуй дулаан, жилд орох хур тунадас 80 мм буюу маш бага тунадастай, чийг дулааны хангамж хүрэлцээгүй буюу хуурай, хэт хуурай уур амьсгалтай нутаг тул усалгааны нормыг дээд хязгаараар нь тооцов.

**Хүснэгт 6. Усалтын системийн талбайд тариалах таримлын жилийн ус хэрэглээ (Нормоор)**

Таримлын нэр	Усалтын норм, м <sup>3</sup> /га	Тариалах талбай, га	Жилийн ус хэрэглээ, м <sup>3</sup>
Үр тариа	2500-2800	111.8	313040
Төмс	3100-3400	74.4	252960
Хүнсний ногоо /байцаа/	3500-3900	10.6	41340
Эрдэнэшиш	2800-3100	55.9	173290
Нийт		252.7	780630

**Хүснэгт 7. . Тарималыг нэг удаа услахад шаардагдах усны хэмжээ (Нормоор)**

Таримлын нэр	Нэг удаагийн услах норм, м <sup>3</sup> /га	Тариалах талбай, га	Нэг удаа услахад шаардагдах ус хэрэглээ, м <sup>3</sup>	Услах тоо	Жилийн ус хэрэглээ, м <sup>3</sup>
Үр тариа	400.0	111.8	44720	6	268320
Төмс	500.0	74.4	37200	7	260400
Хүнсний ногоо /байцаа/	350.0	10.6	3710	6	22260
Эрдэнэшиш	400.0	55.9	22360	6	134160
Нийт		252.7	107990	-	685140

Нэг удаа услахад нийт 107990 м<sup>3</sup> ус ашиглана. Нэг удаагийн усалгааг 5-6 хоног хийнэ.

Усалтын системийн зураг төсөлд DYP – 7 болон DYP – 8 маркийн хоёр төрлийн нийт 5 ширхэг бороожуулагч машиныг ашиглахаар төлөвлөсөн. Ингэхдээ нэгэн зэрэг 3 бороожуулагч машин ажиллах ба хоногт хоёр ээлжээр 16 цаг ажиллана. Бороожуулах машины ус хэрэглээ нь:

**DPY-8 маркийн бороожуулагч:**

$$Q_{DPY-8} = Q_{б.м} \times N = 63.06 \times 3 = 189.18 \text{ л/с} = 681.048 \text{ м}^3/\text{цаг} \times 16 \text{ цаг} = 10896.768 \text{ м}^3/\text{хон болно.}$$

Үүнд:

$Q_{DPY-8}$ - бороожуулах машины нийт ус хэрэглээ

$Q_{б.м}$ - бороожуулах машины хүчин чадал (63.06 л/с)

N- нэгэн зэрэг ашиглах машины тоо (3 ш)

DPY-8 маркийн 3 ширхэг бороожуулах машины нэг хоногийн (хоногт 16 цаг ажиллахаар тооцов) усны хэрэглээ нь 10896.768 м<sup>3</sup> байна.

**DPY-7 маркийн бороожуулагч:**

$$Q_{DPY-7} = Q_{б.м} \times N = 55.56 \times 2 = 111.12 \text{ л/с} = 400.032 \text{ м}^3/\text{цаг} \times 16 \text{ цаг} = 6400.512 \text{ м}^3/\text{хон болно.}$$

Үүнд:

$Q_{DPY-7}$ - бороожуулах машины нийт ус хэрэглээ

$Q_{б.м}$ - бороожуулах машины хүчин чадал (55.56 л/с)

N- нэгэн зэрэг ашиглах машины тоо (2 ш)

DPY-7 маркийн 2 ширхэг бороожуулах машины нэг хоногийн (хоногт 16 цаг ажиллахаар тооцов) усны хэрэглээ нь 6400.512 м<sup>3</sup> байна.

DPY-8 болон DPY-7 маркийн 5 машиныг бүрэн хүчин чадлаар нь хоногт 16 цаг ажиллуулахад **17297.28 м<sup>3</sup>/хон** ус хэрэглэх тооцоо гарч байна.

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Услалтын системийн ус хуримтлуулах усан сангийн цэвэр эзлэхүүн нь 18000 м<sup>3</sup> тул нэг удаа бүтэн дүүргэсэн үед бороожуулагчийн ус хэрэглээг нэг хоногт хангахаар байна. Ийм усан санг хоногийн тохируулгатай усан гэж нэрлэх бөгөөд бороожуулагчийн ус хэрэглээг тасалдуулахгүй хангахын тулд шөнө нь усаа хуримтлуулж дүүргэх шаардлагатай.

Услалтын системийн усны эх үүсвэр болох Бодонч голын олон жилийн дундаж урсац 1.14 м<sup>3</sup>/сек, урсгалын хурд ихтэй, ус бага үедээ 1.0 м/сек давах ба үерийн үед хавцалын хэсэгт 2-3 м/сек хүрэх нөхцөлтэй. Харин 75 хувийн хангамшилтай, гачиг буюу бага устай үеийн зарцуулга 0.69 м<sup>3</sup>/с байна.

Бодонч голын урсцыг хамгийн гачиг үеэр нь тооцвол (0.69 м<sup>3</sup>/с) нэг хоногт 59616 м<sup>3</sup> усны нөөц хуримтлагдана. Харин олон жилийн дундаж урсацаар тооцвол (1.14 м<sup>3</sup>/сек) нэг хоногт 98496 м<sup>3</sup> ус хуримтлагдана.

Бороожуулагчийн хоногийн ус зарцуулга нь **17297.28 м<sup>3</sup>** байх ба энэ нь Бодонч голын гачиг урсацын 29 хувийг, олон жилийн дундаж урсацын 17.56 хувийг тус тус эзэлж байна. Бодонч гол нь Бодончийн хавцлаас гараад Алтай сумын шинэ төвийг дайран, хуучин сумын төвийн буурь Бор үзүүр өнгөрч Цонжийн говийн элс рүү шурган ордог. Иймээс Бодонч голын урсацын 50%-ыг усалгаанд авч ашиглаж болох тул усны эх үүсвэрийн нөөц хэрэглээнээс их буюу хангалттай хүрч байна.

***Ойн зурвас, ногоон байгууламжийн усалгаа:***

Услалтын системийн зураг төсөлд тариалангийн талбайг тойруулан 3 эгнээ, гол сувгийн дагуу 2 эгнээ ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн. Ойн зурвасыг эгнээ хооронд 3 м зайтай, мод хооронд 3 метр зайтай байгуулна гэж үзвэл тариалангийн талбайг тойруулан 12800 ширхэг, гол сувгийн дагууд 3246 ширхэг, нийт 16046 ширхэг мод тарина.

Нэг ширхэг модыг нэг удаа услахад 40 литр ус зарцуулах ба модыг тарьсан сард 4 удаа, дараагийн сараас эхлэн сард 2-3 удаа, хавар намрын цэнэг усалгааг 3, 10-р саруудад нэг удаа хийнэ. Ингэж тооцоход нийт ойн зурвасын нэг удаагийн усалгаанд 641840 литр буюу 641.84 м<sup>3</sup>, жилд 16 удаа усалгаа хийхэд 10269440 литр буюу 10269.44 м<sup>3</sup> ус хэрэглэх тооцоо гарч байна. Ойн зурвасын усалгааг энэ тооцсон хэмжээгээр эхний 2 жил услах ба 3 дахь жилээс моднуудын амьдрах чадвар тогтворжин дасан зохицох тул байгалийн усалгаагаар услагдана.

**Хүснэгт 8. Ойн зурвасын ус хэрэглээ**

№	Усалгааны төрөл	Тарих модны тоо, ш	1 ширхэг мод услах усалгааны норм, л/мод	Нэг удаа услахад хэрэглэх усны хэмжээ, л	Жилд услах тоо	Жилд хэрэглэх усны хэмжээ
1	Мод	16046	40	641840	16	10269440 л (10269.44м <sup>3</sup> )

***Төслийн нийт ус хэрэглээ:***

Төслийн үйл ажиллагааны үед таримлын усалгаа, ойн зурвас болон ажилчдын унд ахуйн зориулалтаар ашиглах нийт усны хэмжээг тооцоолж Хүснэгт 2-9-д үзүүлэв. Энэхүү төсөл хэрэгжсэнээр жилд 792099.44 м<sup>3</sup> ус хэрэглэх тооцоо гарч байна.

**Хүснэгт 2- 1. Төслийн нийт ус хэрэглээний тооцоо**

№	Үзүүлэлт	Хоногийн ус хэрэглээ, м <sup>3</sup>	Жилийн ус хэрэглээ, м <sup>3</sup>
1	Таримлын ус хэрэглээ	17297.28	780630
2	Унд, ахуйн хэрэглээний ус	5	1200
3	Ойн зурвас, ногоон байгууламжийн усалгаа	48.9	10269.44
<b>Нийт ус хэрэглээ</b>		<b>17351.18</b>	<b>792099.44</b>

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Үрийн хэрэглээ**

“Боомын ам” услалтын системийн 1 га талбайд тариалах таримлын үрийн хэрэглээг Хүснэгт 2-9-д үзүүлэв. Хүснэгтээс үзэхэд жилд 201.1 тн үр хэрэглэх тооцоо гарч байгаагаас үр тарианы талбайд 13.4 тн, төмсний талбайд 186.0 тн, хүнсний ногооны талбайд 0.032 тн, эрдэнэшишийн талбайд 1.7 тн үр тарихаар байна.

**Хүснэгт 9. . Услалтын системийн талбайд тариалахаар төлөвлөж буй таримлын үрийн хэрэглээ (Жилд)**

Таримлын нэр	Тариалах талбай, га	Үрийн хэрэгцээ	
		1га-д /тн/	Бүгд /тн/
Үр тариа	111.8	0.12	13.4
Төмс	74.4	2.5	186.0
Хүнсний ногоо /байцаа/	10.6	0.003	0.032
Эрдэнэшиш	55.9	0.03	1.7
	252.7	-	201.1

Түүнчлэн салхины хүч, ууршилтаас хамгаалсан ойн зурвасыг гол сувгийн дагууд 43920 м<sup>2</sup> талбайд, услалтын системийн талбайг тойруулан 59200 м<sup>2</sup> талбайд тус тус байгуулахаар төлөвлөсөн. Ойн зурваст нийт 19292 ширхэг модны суулгац тарьна.

**1.10.2 Эрдэс бордоо, пестицидийн хэрэглээ**

“Боомын ам” услалтын системийн 252.9 га талбайд үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо тариалахад хог ургамал устгах зориулалт бүхий 220.0 л, 78.26 кг гербицид, хортон шавж устгах зориулалт бүхий 34.0 л инсектицид, хөгц мөөгөнцөр устгах, үр ариутгах зориулалт бүхий 33.53 кг, 85.86 л фунгицид, хөрсний үржил шимийг тэтгэх зориулалт бүхий 34564 кг азот болон фосфорын бордоо хэрэглэхээр төлөвлөжээ.

Эдгээр бодисууд нь Монгол Улсад 2023 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт (БОАЖСайд, ХХААХҮСайд, ЭМСайдын 2023 оны А/52, А-42, А/71 дугаар хамтарсан тушаалын 1-р хавсралт), Монгол Улсад 2022 онд газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордооны жагсаалт (БОАЖСайд, ХХААХҮСайд, ЭМСайдын 2022 оны А/52, А-42, А/71 дугаар хамтарсан тушаалын 2-р хавсралт)-нд тус тус орсон байна. Эрдэс бордоо болон ургамал хамгааллын бодисуудын төрөл, хэрэглэх хэмжээг Хүснэгт 10-г үзүүлэв.

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хүснэгт 10. Эрдэс бордоо болон ургамал хамгааллын бодисуудын хэрэглээ (Жилээр)**

№	Нэр төрөл		Томьёо	/CAS/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт
<b>А. Үр тариа</b>							
1	Үр ариутгах	Скарлет (Имазалил, 100 г/л)	$C_{14}H_{14}Cl_2N_2O$	35554-44-0	л	8.94	Буудай, арвайн хатуу харуу, тоосон харуу, хуурамч тоосон харуу, чулуут харуу, гельминтоспориоз ба фузариозын үндэсний илжрэл, үрийн хөгц, септориоз зэрэг өвчний эсрэг 0.3-0.4 л/т тунгаар тарих үрийг ариутгаж зааврын дагуу хэрэглэнэ.
2	Гербицид	Дротик, ККР	$C_{16}H_{22}Cl_2O_3$	1928-43-4	л	111.8	Үр тарианы талбайн хос үрийн талт хог ургамлын эсрэг бутлалтаас гол хатгалтын үед 0.7-1.0 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
3	Азотын бордоо (Мочевин -46-0-0)		$CO(NH_2)_2$	57-13-6	кг	4472	Үрийн чанарыг сайжруулах зорилгоор (40 кг/га) тарилтын ба ургалтын үед ургамал, хөрсний шинжилгээ, авах ургацын хэмжээг үндэслэн зааврын дагуу хэрэглэнэ.
<b>Б. Төмс</b>							
1	Инсектицид	Децис	$C_{22}H_{19}Br_2NO_3$	52918-63-5	л	29.76	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавжийн эсрэг 0.3-0.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
2	Үр ариутгах	ТМТД, ВСК	$C_6H_{12}N_2S_4$	137-26-8	л	74.4	Үр тариа, төмс, хүнсний ногооны мөөгөнцөр, бактерийн өвчний эсрэг тарилтын өмнө үр ариутгалыг 3-4 л/т тунгаар зааврын дагуу хийнэ.
3	Фунгицид	Акробат, WP	$C_{21}H_{22}ClNO_4$	110488-70-5	кг	33.48	Төмсний фитоптор, альтернариоз өвчний эсрэг ургамал ургалтын хугацаанд 0.40-0.45 кг/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
4	Гербицид	Зенкор (Метрибузин, 70%)	$C_8H_{14}N_4OS$	21087-64-9	л	104.16	Лооль, төмсний талбайн нэг наст хос үрийн талт, зарим төрлийн үет хог ургамлын эсрэг 0.7-1.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
5	Азотын бордоо (Мочевин -46-0-0)		$CO(NH_2)_2$	57-13-6	кг	8928	Үрийн чанарыг сайжруулах зорилгоор (40 кг/га) тарилтын ба ургалтын үед ургамал, хөрсний шинжилгээ, авах ургацын хэмжээг үндэслэн зааврын дагуу хэрэглэнэ.
6	Фосфорын бордоо		$Ca(H_2PO_4)_2$	0-46-0	кг	7440	Таримлын төрлөөс хамааран бордоонуудыг хамтад нь хөрс боловсруулалт ба тарилтын үед ургамал, хөрсний шинжилгээ, авах ургацын хэмжээг үндэслэн зөвлөсөн тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
<b>В. Хүнсний ногоо</b>							
1	Инсектицид	Децис	$C_{22}H_{19}Br_2NO_3$	52918-63-5	л	4.24	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавжийн эсрэг 0.3-0.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
2	Үр ариутгах	Бенорад	$C_{14}H_{18}N_4O_3$	021-02-1741-1	кг	0.053	Үр ариутгалын фунгицидыг үрийн өвчний эсрэг 2-3 кг/т тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3	Гербицид	Зенкор (Метрибузин, 70%)	$C_8H_{14}N_4OS$	21087-64-9	л	4.24	Лооль, төмсний талбайн нэг наст хос үрийн талт, зарим төрлийн үет хог ургамлын эсрэг 0.7-1.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
4	Азотын бордоо (Мочевин -46-0-0)		$CO(NH_2)_2$	57-13-6	кг	1272	Үрийн чанарыг сайжруулах зорилгоор (40 кг/га) тарилтын ба ургалтын үед ургамал, хөрсний шинжилгээ, авах ургацын хэмжээг үндэслэн зааврын дагуу хэрэглэнэ.
5	Фосфорын бордоо		$Ca(H_2PO_4)_2$	0-46-0	кг	1272	Таримлын төрлөөс хамааран бордоонуудыг хамтад нь хөрс боловсруулалт ба тарилтын үед ургамал, хөрсний шинжилгээ, авах ургацын хэмжээг үндэслэн зөвлөсөн тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
<b>Г. Эрдэнэшиш/Овьёос</b>							
1	Үр ариутгах	Тебу 60, МЭ (Тебуконазол, 60 г/л)	$C_{16}H_{22}ClN_3O$	107534-96-3	л	2.52	Буудай, арвай, хошуу будааны хатуу харуу, тоосон харуу, хуурамч тоосон харуу, чулуут харуу, гельминтоспориоз ба фузариозын үндэсний илжрэл, үрийн хөгц, септориоз зэрэг өвчний эсрэг 0.4-0.5 л/т тунгаар тарих үрийг ариутгахад зааврын дагуу хэрэглэнэ.
2	Гербицид	Лазурит, СП (Метрибузин, 700 г/кг)	$C_8H_{14}N_4OS$	21087-64-9	кг	78.26	Төмс, лооль, шар буурцаг, эрдэнэ шишийн талбайн хог ургамлын эсрэг 1.1-1.4 кг/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
3	Азотын бордоо (Мочевин -46-0-0)		$CO(NH_2)_2$	57-13-6	кг	11180	Үрийн чанарыг сайжруулах зорилгоор (40 кг/га) тарилтын ба ургалтын үед ургамал, хөрсний шинжилгээ, авах ургацын хэмжээг үндэслэн зааврын дагуу хэрэглэнэ.

## **ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Эцсийн бүтээгдэхүүн**

Энэхүү төсөл хэрэгжсэнээр 252.7 га талбайд төмс, хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамал тариалж, 10.3 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн болно.

Тарималыг төрлөөр нь авч үзвэл 111.8 га талбайд 13.4 тн хөх тарианы үр тариалж 212.4 тн хөх тариа, 55.9 га талбайд 1.7 тн тэжээлийн ургамлын үр тариалж 185.9 тн тэжээлийн ургамал (эрдэнэшиш, овъёос), 74.4 га талбайд 186 тн төмсний үр тариалж 718.7 тн төмс, 10.6 га талбайд 0.032 тн хүнсний ногооны үр тариалж 82.9 тн хүнсний ногоог тус тус хураан авна.

### **Хог хаягдал**

Услалтын системийн барилга, газар шорооны ажлын үед ахуйн хатуу, шингэн хаягдал болон барилгын материалын хаягдал үүснэ. Харин газар тариалан үйлдвэрлэлийн үед ахуйн хатуу, шингэн хаягдлаас гадна химийн бордоо, ургамал хамгааллын бодисуудын үлдэгдэл, сав баглаа боодлын хаягдал, машин механизм, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний үед гарах аюултай хаягдлууд үүсэхээр байна.

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

Ховд аймгийн Алтай сумын нутагт хэрэгжихээр төлөвлөж буй “Боомын ам” услалтын системийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Ийнхүү ТЖБОМТ-г батлагдсаны дараа төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх үүрэгтэй ба түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг жилийн эцсээр буюу 11 дүгээр сарын 01-ний дотор БОАЖСайдын А-618 тушаалын 3-р хавсралтын дагуу боловсруулж, аймгийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

ТЖБОМТ-ний биелэлтийн тайланг газар дээр нь хянаж, дүгнэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах ба ажлын хэсэг нь ТЖБОМТ-ний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн оноогоор дүгнэнэ. Биелэлтийн тайлангийн уг дүнгээр 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

Харин төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна.

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ”  
УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

Жич: 2022онд ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй бөгөөд Агро Альфа. ХХК 2022 онд тус ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан бөгөөд 2022 онд төлөвлөгдсөн ажлууд 2023 оны 6 дугаар сараас хийгдэж эхлэх тул 2022 онд төсөвлөгдсөн байгаль хамгаалах зардлууд тухайн үед зарцуулагдаж эхлэх юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

**Хүснэгт 11. Зардлын нэгдсэн хүснэгт**

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	1 жилийн зардал / төг/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	46 300,0
2.	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	103 750,0
3.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Осол, Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17000,0
6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	71000,0
7.	Удирдлага зохион байгуулалт	-
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3469,0
	<i>Нийт</i>	241519,0



**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2.2 Услалтын системийг барих болон үйл ажиллагааны үед үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
1		Цавуулаг материал болон усалгааны аргуудаар шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах				
2	Материал тээвэрлэх болон ашиглалтын үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Шороон замаар зорчих тээврийн хэрэгслүүдийн хурдыг 30-40 км/цаг-аар хязгаарлах буюу энэ хурднаас хэтрүүлэхгүй байх зохицуулалт хийх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	12000	2023 онд	-Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016 Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс, хайрга, дайргын стандарт MNS-392-98 Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
3		Хатуу хучилттай авто замаас салаад тариалангийн талбай хүртэл шороон замаар зорчих хэсэгт авто замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулж, тээврийн хэрэгслүүдийг зөвхөн нэг замаар зорчих нөхцөлийг бүрдүүлэх, шинээр олон салаа шороон зам үүсгэхгүй байх				
4	Услалтын системийн барилга газар шорооны ажлын үед ашиглах элс, хайрга, цемент зэрэг материалуудын овоолгоос салхины үйлчиллээр тоос босох	Задгай талбайд овоолох барилгын материалыг газрын гадаргаар тархахаас сэргийлж хаалт, хашилт хийх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд		2023 онд	
5	Материал тээвэрлэх үед ачааны хэсгээс тоос үүсэх, асгарах	Салхинд хийсч тоос үүсгэхгүйц материал тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн ачааны хэсгийг битүүмжлэн хучих арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	800,0	2023 онд	

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>6</b>	Хүнд даацын машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаар бохирдуулах	Барилга, газар шорооны ажлын үед ашиглах хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжинд сайн чанарын түлш ашиглаж агаарт ялгарах хийн төлөвт бохирдуулагчийг багасгах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	“Бензин хөдөлгүүртэй автомашин–угааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга” MNS 5013:2009
<b>7</b>	Хүнд даацын машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаар бохирдуулах	Нийт машин механизмуудыг үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай бол хөдөлгүүрийг шинэчилж сайжруулах, хорт угаа ихээр ялгаруулж буй машин техникийг барилгын ажилд ашиглахгүй байх, шаардлагатай үед хаягдал утааг шүүх шүүлтүүр, катализатор хэрэглэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	“Дизель хөдөлгүүртэй автомашин–угааны тортогжилтын ЗДХ ба хэмжих арга” MNS 5014:2009  Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008
<b>Дүн</b>				<b>12800.0</b>		
<b>2. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
<b>1</b>	Шаардлагагүй газарт газар хөндөх, ухаш овоолго үүсгэж газрын гадарга, хөрсөн бүрхэвчийг талхлан доройтуулах	Барилгажих талбайн гадна талаар хамгаалалтын зурвас байгуулж, хамгаалалтын зурвас доторх газарт төлөвлөлт, зураг төслийн дагуу үйл ажиллагаа явуулах, тухайн орчимд тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байршуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>1000,0</b>	2023 онд	✓Барилгын тухай хууль, 2016 он Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он
<b>2</b>	Хөрсний үржил шим алдагдах, эвдрэл үүсэх	Нөлөөлөлд өртөөгүй эрүүл талбайг хөндөж хөрс хуулах бол өнгөн хөрсийг тусгай талбайд хадгалж, барилгын ажил дууссаны дараа эвдэрсэн талбайг нөхөн сэргээхдээ ашиглах, аль болох богино хугацаанд олон наст ургамлын үр тарих замаар хөрсийг нөхөн сэргээж элэгдлээс хамгаалах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>5000,0</b>	2023 онд	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008
<b>3</b>	Хөрсний үржил шим алдагдах, эвдрэл үүсэх, хатуу хог хаягдлаар бохирдох	Барилгын ажлын үед нэг цэгээс дараагийн цэг рүү шилжих шилжилт тутамд засвар дууссан газрын нөлөөлөлд өртсөн гадаргыг нөхөн сэргээж ухаш, овоолго	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>2000,0</b>	2023 онд	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 : 2008

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устгах	үлдээхгүй байх, хатуу хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх				Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019 Байгаль орчин. Газар. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3473:1983
<b>4</b>		Барилгын материалуудыг аль болох нэг цэгт төвлөрүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	
<b>5</b>	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устгах	Ажлын үед овоолсон шороо болон бусад хэт налуу орчинг багасгах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	
<b>6</b>		Экскаватороор ухсан нүхийг ил орхихоос сэргийлэх, усалгааны хоолой суулгах шуудуу гаргахад нягтруулдаг техник ашиглах				
<b>7</b>		Барилгын талбай, агуулах саравч, ажилчдын орон байрыг аль болох бага талбай эзлүүлэн байрлуулах				
<b>8</b>	Хөрс боловсруулалтыг буруу арга техникээр хийснээс үүдэж хөрсний үржил шим алдрах, доройтох	Хөрсний өнгөн ба үндсэн боловсруулалтыг зөв арга техникийн дагуу гүйцэтгэж хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл, доройтлыг хамгийн бага байлгахад анхаарах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	
<b>9</b>	Химийн бордоо, пестицидийн зохисгүй хэрэглээнээс үүдэж хөрс бохирдох	Химийн бордоо, пестицидийн хэрэглээнд хяналт тавих, тариалангийн талбайн хөрсөнд лабораторийн шинжилгээ хийлгэж шаардлагатай үед зохих нормоор нь химийн бордоог хэрэглэх, пестицидийн хэрэглээнээс аль болох татгалзах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	
<b>10</b>	Хөрсийг нефтийн бүтээгдэхүүн, хүнд металаар бохирдуулж болзошгүй.	Бензин, шатах тослох материалыг асгарч, ууршихааргүй байдлаар сайтар таглаж битүүмжлэн нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлан хадгалах, шатах тослох материалаар хөрс бохирдохоос сэргийлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>500,0</b>	2023 онд	
<b>11</b>	Бүх төрлийн шатах, тослох материалаар ажилладаг машин	Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг нэн даруй хусаж	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	<b>ҮАЗ</b>	2023 онд	

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	механизм, тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үед шатах тослох материал асгарч хөрс бохирдуулах	аван хөрсний гүн рүү нэвчихээс сэргийлэх				
12		Шатах тослох материал их хэмжээгээр асгарсан бол элс, даавуу зэрэг шингээгч материалд шингээн авч битүү саванд хийх, асгарсан хэсгийн хөрсийг хуулж авах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
13	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаях, асгаснаас хөрс нянгаар бохирдох	Ахуйн хатуу, шингэн хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хуримтлуулах, зайлуулах арга хэмжээ авах, ил задгай хог хаягдал хаях, асгах, хур хог үүсгэхийг хатуу хориглоно.	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
14	Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх	Барилга, газар шорооны ажил бүрэн дууссаны дараа нөлөөлөлд өртсөн нийт талбайг нөхөн сэргээж, хуучин төрх байдалд нь оруулах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг барилгын ажил дууссанаас хойш 10-15 хоногт багтаан бүрэн хийж дуусгах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2020
15		Тариалангийн талбайн орчимд 2 хүн зэрэг зөрж болохуйц 1.5-2.0 метр өргөнтэй явган хүний замыг байгалийн чулуугаар хийж, явган хүний замаас гадуур алхахгүй байхыг нийт ажилчдад анхааруулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
	Дун			8500.0		
<b>3. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, БАГАСГАХ, АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
1	Гадаргын усны урсац, горим өөрчлөгдөх	Барилгын ажлын үед голын байгалийн үндсэн голдирол, урсацыг өөрчлөх үйл ажиллагаа явуулахгүй байх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023	
2		Барилгын ажлын үед усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд (голын эргээс 50 метрээс доошгүй	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		зайд болон гол мөрний татамд) хамаарах газраас элс, хайрга чулуу авч ашиглахгүй байх				<p>Усны тухай хууль, 2012 он</p> <p>Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”</p>
3	Ус, салхины нөлөөгөөр эрэг нурах	Толгойн барилга болон гол сувгийн дагуух эрэгт чулуун хашлага хийж эргийн нуруулт үүсгэхээс хамгаалах;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	5000,0	2023 онд	
4	Гадаргын болон газрын доорх ус хатуу, шингэн хаягдлаар бохирдох	Ахуйн болон барилгын хатуу, шингэн хаягдлын түр цэг, ажилчдын бие засах газрыг усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс гадагш (Бодонч голын эргээс 200 метрээс доошгүй зайд) байрлуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
5		Голын усанд машин угаах, голын ойр орчимд бие засах, хог хаягдал ил задгай хаяхгүй байх талаар барилгын ажилчдад хатуу анхааруулах ба үүнд талбайн инженер хатуу хяналт тавьж ажиллах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	1000,0	2023 онд	
6		Барилгын ажил явагдах талбаруудад зөөвөрлөн ашиглаж болохуйц био ариун цэврийн байгууламж байрлуулан ашиглах, ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх талаар мэдээлэл өгч байх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	2000,0	2023 онд	
7		Хатуу хаягдлын түр цэгүүдийг стандартын шаардлагад нийцүүлэн сайтар битүүмжлэн байгуулах ба хаягдлыг богино хугацаанд төвлөрсөн цэг рүү зөөвөрлөх, хатуу хог хаягдал гол руу хийсч орохоос сэргийлэх	<b>Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгаж өгсөн</b>		2023 онд	
8	Барилгын ажлын үед илүүдэл хаягдал усаар	Барилгын талбайн гадаргын урсал голын ус руу орохоос сэргийлэн хамгаалалтын суваг байгуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	гадаргын ус бохирдуулах					
9	Усан орчныг бохирдуулах Химийн бордоо, пестицидийн зохисгүй хэрэглээнээс үүдэж	Бүх машин механизм, ажилчдын голын суваг руу орох, гарах гарцыг хатуу зааглаж тогтооно. Энэ нь суваг болон амьдрах орчны ойролцоох хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийг багасгана.	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	1000,0	2023 онд	
10	гадаргын урсац, хөрсний усаар дамжин гадаргын болон газрын доорх ус бохирдож болзошгүй	Бохирдуулагч бодисууд суваг руу орох эрсдэлийг багасгахын тулд суваг руу орох бүх машин механизмыг нэвтрэхээс өмнө цэвэрлэж, бохир алдагдаж асгарч буй эсэхийг шалгана.	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
11	Усны нөөц ашигласны төлбөр төлөх	Ус ашиглуулах дүгнэлтэнд үндэслэн Хар нуур-Ховд голын сав газраас ус ашиглах зөвшөөрөл авч, ус ашиглах гэрээг жил бүр шинэчлэн байгуулах, ус ашиглах гэрээнд тусгасан үүрэг хариуцлагыг мөрдөж гэрээний дагуу үйл ажиллагаа явуулах	Ус ашиглалтын дүгнэлтээр тогтоогдсон дүнгээр			
12	Услалтын системийн барилга байгууламжуудын битүүмжлэл муу байснаас ашиглалтын үед шүүрэлт үүсч, усны алдагдал ихсэх, ус хэрэглээ тооцоот хэрэглээнээс давах	Услалтын системийн барилга байгууламжууд буюу усан сан, гол суваг, далд сувгийн битүүмжлэлийг стандартын дагуу хийж, шүүрэлт үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	✓Усны тухай хууль, 2012 он ✓Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он Хүрээлэн байгаа орчин. Усны нөөц, ус ашиглалт, хамгаалалт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 6694 : 2017
13		Шүүрэлт үүсгэхгүй байхын тулд гол сувгийг бетоноор доторлох, усан санд плёнк дэвсэх, гол сувгийн эргийн нуралтаас сэргийлэхийн тулд чулуун өрлөг хийх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
14		Газрын доорх усны бохирдол, усны түвшнийг тогтмол хэмжиж, усны чанарын стандарттай харьцуулан тэмдэглэл хөтлөх, мониторингийн	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		цооногийн шинжилгээний үр дүнг тусгах;				
15		Услалтын системийн барилга байгууламжууд шүүрэлт үүсгэж буй эсэхэд тогтмол хяналт тавьж, шүүрэлт үүсгэж байвал нэн даруй засварлах арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
<b>Дүн</b>				<b>9000.0</b>		
<b>4. УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
1		Барилгын ажлын төлөвлөлт, газар ашиглалтыг зөв хийж ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд байлгах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	✓Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он ✓Ургамал хамгааллын тухай хууль, 2007 он Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 25 – ны өдрийн 153 дугаар тогтоол, Ховор ургамлын жагсаалт
2	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устгах, доройтох	Барилгажих талбайд ховор, нэн ховор статустай, эмийн ач холбогдол бүхий хамгаалах шаардлагатай ургамал байвал шилжүүлэн суулгах арга хэмжээ авах, нэн ховор, ховор, эмийн ашигт ургамлуудыг түүж бэлтгэхгүй байх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
3		Барилгын материал, машин механизмуудыг ургамлан нөмрөг бага буюу аль холбох халцгай газарт байрлуулах, байгалийн ургамалтай газарт барилгын материал буулгах, машин механизмын зогсоол болгон ашиглахгүй байх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
4	Ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал тархаж тариалалт болон ургацад сөргөөр нөлөөлөх	Тариалангийн талбай болон түүний ойролцоох ургамлан нөмрөгт хяналт тавьж, тархалт, олшролтын шалтгаан, хэмжээ, хүрээг тогтоох, тархаж болзошгүй голомтыг халдваргүйжүүлэх арга хэмжээ авах, ургалтын хугацаанд хог	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	3000,0	2023 онд	

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		ургамлыг байнга устгаж, талбайг цэвэрхэн байлгах				
5		Мэргэжлийн шинжээчийг томилж, таримлын болон талбай түүний орчинд ургах ургамлын ургалт, ургаж буй нөхцөлд хяналт тавих, хяналт мониторингийг тогтмол хугацаанд хийх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
6		Талбайд үлдсэн ургамлын үлдэгдэл хаягдлыг цэвэрлэж, хог хаягдлыг зөөн эко бордоо болгож ашиглах арга хэмжээг судлах хэрэгжүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	4000,0	2023 онд	
7		Намар тариалангийн талбайн хөрсийг өнгөц эргүүлэн хагалах, хөрсөнд өвөлжиж эхэлсэн шавжийн авгалдай хүүхэлдэйг ил гаргаж орчинг өөрчлөх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
	<b>Дүн</b>			<b>7000.0</b>		✓
<b>5. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
1	Урьдчилан хяналт шалгалт хийгээгүйн улмаас амьтдад хор хохирол учруулах	Барилгажих талбай болон түүний ойр орчимд ямар нэг амьтны төрөл зүйл байгаа эсэх, амьтны үүр, үржлийн дэвсгэр нутаг байгаа эсэхийг тодорхойлох арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
2	Тариалангийн талбайн орчмын ЦДАШ дээр шувуу сууж тогонд цохиулах, тариалангийн талбайн дээгүүр шувууны бөөгнөрөл үүсэх	Тариалангийн талбайн орчимд шувуу үргээгч суурилуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	1000,0	2023 онд	
3	Зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад учруулах	Хэрэв барилгын ажлын явцад зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнтэй таарвал үргээлгүй зам тавьж өгөн өнгөрөөж байх;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	



**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	Нүүдлийн шувуудыг үргээх, амьдарлын хэв маягийг нь өөрчлөх, тааламжгүй нөхцөлийг бүрдүүлэх	Нүүдлийн шувууд дайран өнгөрдөг хугацаанд шувуудыг үргээдэг хүчин зүйлүүдэд хяналт тавьж, ажилчдад мэдээлэл өгч шувуудыг аль болохоор үргээж цочоохгүй байх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
5	Аюулд орсон амьтдад шуурхай тусламж үзүүлж чадаагүй бол тоо толгой нь хорогдох	Бэртэж гэмтсэн, аюулд орсон зэрлэг ан амьтантай таарвал орон нутгийн байгаль хамгаалагчид мэдэгдэж шуурхай арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
6	Хууль бус ан агнуурын үйл ажиллагаа явагдах	Барилгын ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх, худалдаалахгүй байх талаар анхааруулга өгч, хяналт тавьж ажиллах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
7	Далангийн хаалтыг хаалттай байлгаснаас загас дамжин өнгөрөх боломжгүй болох	Суваг шуудуу, толгойн барилгын хаалт зэргийг загас өнгөрүүлэх боломжтой байхаар төлөвлөн байгуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ	2023 онд	
8	Усан орчинд амьдарч буй амьтдын амьдрах орчныг өөрчлөх,	Гол суваг, усан санд загас орвол амьдрах орчны хувьд тохиромжгүй тул толгойн барилгад загас орохоос сэргийлсэн тор тавьж гол суваг руу загас орохгүй дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	2500,0	2023 онд	
9		Гол суваг, усан санд загас орвол амьдрах орчны хувьд тохиромжгүй тул толгойн барилгад загас орохоос сэргийлсэн тор тавьж гол суваг руу загас орохгүй дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	4500,0	2023онд	
10	Тариалангийн талбайд мал орж таримал идэх, намар хураалтын дараа үлдэгдэл хөлдүү төмс,	Тариалангийн талбайг битүү хашаагаар хашаалах, мал амьтан дотогш орохоос сэргийлж хашааг байнга хаалттай байлгаж, ургац	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	1000,0		

**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “БООМЫН АМ” УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

хүнсний ногоо (хөлдүү) идэн хордож болзошгүй	хураалтын дараа талбайг сайтар цэвэрлэх				
<b>Дүн</b>			<b>9000.0</b>		
<b>Нийт дүн</b>			<b>46300.0</b>		

**2.3. Нөхөн сэргээлийн төлөвлөгөө**

Барилгын ажлын үед эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах ажлуудын төлөвлөгөөг энэ хэсэгт тусгасан ба нийт 103750,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөв.

